



**МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ
БАЯЛГИЙН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛҮҮДЭД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС
ӨГӨХ ДҮГНЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ
2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр

АГУУЛГА

1. Төсвийн бодлогын талаар	3
2. Нийт орлого ба тусламжийн талаар	5
3. Нийт зарлага ба цэвэр зээлийн талаар	10
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар	13
5. Засгийн газрын нийт өр, төлбөрийн талаар	15
6. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн талаар	17
7. Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай	17
8. Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн талаар	18
9. Улсын хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх	19
10. Төсвийн тухай хууль болон төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх	25
11. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх	25

**МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН
САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДЭД ТӨСВИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ**

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8.4.8 дахь заалт, Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23.1 дэх заалтын дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай” хуулийн төсөлд дүгнэлт гаргалаа.

ТТБЗ-ийн зүгээс өргөн мэдүүлсэн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн (ТТБТХ) 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 7.3-т заасан “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэснийг баримталсан эсэх, мөн Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 6.2.1, 6.2.2, 6.3.3, 6.4.1, 27 дугаар зүйл, 32.2-д заасны дагуу боловсруулагдсан эсэхэд голлон анхаарсан болно.

Монгол Улсын 2026 оны төсвийн төслөөс үзэхэд макро эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан төсвийн бодлогын чиглэлийг тодорхойлж, олон нийтийн оролцоог хангаж байгаа зэрэг ахиц дэвшил гарсныг дурдах хэрэгтэй. Энэ нь Засгийн газрын хүчин чармайлтаас гадна 2025 оны төсвийн төслийн хэлэлцүүлгийн явцад Төрийн захиргааны төв байгууллагууд, олон нийтийн оролцоотойгоор төсвийн тулгамдсан асуудлыг бүх нийтээр шүүн хэлэлцсэний үр дүн юм. Үүн дээр 2025 онд эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн нь гол нөлөө үзүүлсэн гэж ТТБЗ үзэж байна. Иймээс төсвийн бодлого төлөвлөлт нь 2010 онд батлагдсан ТТБТХ-ийн хэрэгжилт алдагдаж байсан он жилүүдтэй харьцуулахад 2026 оны төсвийн төсөл тодорхой хэмжээгээр сайжирсан бөгөөд цаашид бодлого, хуулийн хэрэгжилтийн түвшинд анхаарах асуудал цөөнгүй байгааг харгалзан дараах чиглэлүүдээр дүгнэлт гаргалаа.

1. ТӨСВИЙН БОДЛОГЫН ТАЛААР

1.1. Төсвийн бодлогын чиглэл нь эдийн засгийн нөхцөл байдалтай нийцтэй байна. 2026 оны төсвийн бодлогыг “макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, төсвийн зардлын өсөлтийг хязгаарлах, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлэх практик шаардлага үүсэж байна. Энэ нь төсвийн сахилга батыг хангахын зэрэгцээ эдийн засгийн эрсдэлийг бууруулж, урт хугацаанд тогтвортой өсөлтийг хадгалах чухал нөхцөл болж байна”¹ гэж тодорхойлсон. Улс орны эдийн засагт гарсан нааштай өөрчлөлтөөс хамааран 2024 оныг хүртэл хэт тэлж ирсэн төсвийн бодлогыг хязгаарлах, төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшилд эдийн засгийн орон зайг бий болгох асуудал 2025 оны төсвийн тодотголоос эхлэн бодитойгоор хэрэгжиж эхэлж байгаа гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

¹ “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн үзэл баримтлал”-ын 2-р хуудас.

1.2. Төсвийн бодлогын тогтвортой байдлыг хадгалах шаардлагатай байна. Төсвийн төсөлд “макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, төсвийн зардлын өсөлтийг хязгаарлаж, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж хувийн хэвилийг дэмжихийн зэрэгцээ олон нийтийн саналд үндэслэн эрүүл мэнд, боловсролын салбарт түлхүү анхаарна”², “Монгол хүний хөгжил бол хамгийн том МЕГА төсөл байх” тухай дурдсан. Төсвийн тогтвортой байдлыг хангах, зарлагыг бууруулах, мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх нь ихэвчлэн эдийн засгийн хүндрэлтэй үед Засгийн газрын анхаарлын төвд байж, харин эдийн засгийн тэлэлттэй үед орхигдуулж, орлогын өсөлтийг дагуулан зарлагаа тэлдэг байдал давтагдаж ирсэнийг цаашид анхаарах шаардлагатай. Төсвийн бодлого нь эдийн засгийн хөгжлийг дэмжиж, тасралтгүй нэг чиглэлд хэрэгждэг байх тогтвортой орчныг бүрдүүлж дунд, урт хугацаанд баримтлаж хэвших нь зүйтэй байна.

1.3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн дараалал алдагдаж байна. Төсвийн төсөлд “Ирэх жил бол Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулж буй дунд хугацааны хөгжлийн бодлогын эхний жил учраас 2026 оны төсвийн бодлогыг “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэхэд чиглүүлэхийн зэрэгцээ “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний хүрээнд боловсруулаад байна” гэж дурдсан. Гэтэл энэ удаагийн төсвийн төсөл Монгол Улсыг хөгжүүлэх 2026-2030 оны 5 жилийн үндсэн чиглэл батлагдаагүй байхад хэлэлцэгдэхээр байгаа нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7, Төсвийн тухай хуулийн 6.2.7, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.2.3 заалтуудын хэрэгжилтийг сулруулах нөхцөлийг бий болгож байна.

1.4. Монгол Улсын макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд төсвийн болон мөнгөний бодлогын уялдаа хамаарлыг сайжруулах шаардлагатай хэвээр байна. Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд төсвийн хумих бодлого болон мөнгөний хатуу бодлогын хүрээнд макро эдийн засгийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтийг хангах сорилттой тулгарч байна. Улсын төсөв болон төлбөрийн тэнцэл алдагдалтай, инфляцын түвшин зорилтот түвшнээс давсан, гадаад зах зээл дээр уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үнэ буурсан, бусад салбарын идэвхжил сул байгаа өнөөгийн макро эдийн засгийн орчинд төсвийн болон мөнгөний бодлогыг оновчтой зөв тодорхойлж, богино, дунд хугацааны хөгжлийн бодлоготой нягт уялдуулан, жилийн төсвийг төлөвлөх нь туйлын чухал асуудал юм.

1.5. Төсвөөр дамжуулан эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлого хэрэгжих боломж хязгаарлагдаж байна. 2020-2024 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын жилийн дундаж өсөлт 26.2 хувь, нэрлэсэн ДНБ-ий өсөлт 17 хувь байсан тренд цааш үргэлжилбэл гурван жилийн дараа буюу 2028 онд урсгал зардлын ДНБ-д эзлэх хувь 30-аас хэтрэхээр байна. Энэ нь цаашид төсвийн орлого зөвхөн урсгал зардлаа даах төдий хэмжээнд хүрэх, төсвөөр эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжих орон зай хумигдах нөхцөлийг бий болгоно. Иймд төсвийн урсгал зардлыг өсгөж буй хууль эрх зүйн зохицуулалтыг эргэн харах шаардлагатай байна.

1.6. Төсөв, санхүүгийн эрх зүйн зохицуулалтыг тогтвортой байлгах нь төсвийг дунд, урт хугацаанд тогтвортой байлгах гол үндэслэл болно. Төсвийн тухай хууль (2011), Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (2010) зэрэг хуулиуд батлагдсанаас хойш улс орны

² “Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн баримт бичиг”-ийн 26-р хуудас

эдийн засгийн нөхцөл байдал, тухайн жилд авч хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн бодлогоос хамааруулан жил бүр өөрчлөлт оруулж ирснээс шалтгаалан улсын төсөв, санхүүгийн макро бодлого алдагдах нөхцөл үүсээн. Энэ байдлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд оруулсан өөрчлөлтөөр хааж өгсөн боловч тус хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр дахин нэмэлт өөрчлөлт оруулсан нь Төсвийн тогтвортой байдлын талаарх хуулийн дархлаа суларч байгааг харуулж байна.

2. НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүнд Үндэсний баялгийн сангийн орлогын эзлэх хувь өсөх хандлагатай байна. Нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2020 оноос эхлэн жил бүр 29.0-37.0 хувийн өсөлттэй байсан бол 2025 онд өмнөх оноос 3.4 хувь, 2026 онд 7.3 хувиар өсөхөөр тооцсон байна. Нийт орлого ийнхүү нэмэгдэхэд 2018-2024 онд тэнцвэржүүлсэн орлогын өсөлт нөлөөлсөн бол 2025, 2026 оны тухайд Үндэсний баялгийн сангийн орлогыг харгалзан 45.7, 55.5 хувиар нэмэгдэх нь нөлөөлөх магадлалтай байна.

Зураг 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018-2026 оны нийт орлого ба тусламж, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл

Мөн ДНБ-д нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн эзлэх хувийг 2018-2026 оноор харьцуулж үзэхэд Үндэсний баялгийн сангийн орлого болон төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн жилээс жилд нэмэгдэж байгаа бол Тогтворжуулалтын сангийн эзлэх хувь буурах хандлага ажиглагдаж байгаа юм.

Үндэсний баялгийн сангийн орлого 2026 онд энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 1.1 их наяд төгрөгөөр нэмэгдэж, нийт 2,956.1 тэрбум төгрөг болно гэж төлөвлөжээ. Энэ нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1 дэх заалтын дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос Төсвийн тогтворжуулалтын сан болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилж, үлдэх хэсгийн 65 хувь буюу 2,186.9 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд, мөн хуулийн 11.1.2-т заасны дагуу уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос 372.9 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд тус тус төвлөрүүлнэ гэж тооцсонтой холбоотой байна.

Зураг 2. ДНБ-д нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн эзлэх хувь




Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл

Үүнээс гадна Үндэсний баялгийн сангийн хөрөнгө оруулалтын орлогоос 240.3 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд, 156.0 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд хуримтлуулахаар төлөвлөжээ. Хэрэв ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөсөн хэмжээнд бүрдэхгүй, энэ салбарт ажиллаж буй төрийн өмчит компаниуд ашигтай ажиллахгүй бол Үндэсний баялгийн сангийн орлого тасалдах эрсдэл учирч болзошгүй.

2.2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын бүрдүүлэлт эрсдэлтэй хэвээр байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2021-2024 онд хурдтай нэмэгдсэн ч 2025, 2026 онд өсөлтийн хурд нь саарах төлөв ажиглагдаж байна. Тэнцвэржүүлсэн нийт орлого, тусламж 2026 онд 2018 онтой харьцуулахад 3.4 дахин, 2021 онтой харьцуулахад 2.5 дахин өсжээ.

Зураг 3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018-2026 оны тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн (татварын, татварын бус орлогоор ангилсан), тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам (2025)


Төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүнд татварын орлогын эзлэх хувь сүүлийн 9 жилийн дунджаар 90.7 хувь байгаа бол 2023-2026 онд 92.4-94.0 хувь хүртэл тасралтгүй өсөх хандлагатай байна. Засгийн газрын зүгээс 2025, 2026 онд татварын багц шинэчлэл хийх зорилтыг дэвшүүлэн, ирэх онд НӨАТ-ын буцаалтыг хэрэглээний шатлалаас хамааруулан нэмэгдүүлэх бодлого баримтлана гэж зарласан ч төсвийн тэнцвэржүүлсэн

нийт орлогод эзлэх НӨАТ-ын орлого буурахааргүй харагдаж байна. Энэ нь НӨАТ-ын буцаалтын хувийг бага хэрэглээтэй хүмүүст 5 хувь хүртэл нэмэгдүүлэх бодлогоос хамаарч уг татварын суурийг илүү өргөтгөх сорилтыг бий болгож байна.

2.3. Төсвийн татварын бус орлого, түүний дотор ТӨҮГ-ын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлого буурах хандлагатай байна. Татварын бус орлогыг задалж үзвэл 2026 онд хувьцааны ногдол ашгаар 9.3, хүү, торгуулийн орлогоор 17.1, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 22.7, түрээсийн орлогоор 0.2, газрын тосны орлогоор 12.3, навигацын орлогоор 4.3, бусад орлогоор 14.8 хувийг тус тус төвлөрүүлнэ гэж тооцжээ. Эндээс харвал хувьцааны ногдол ашиг өмнөх жилээс 55.4 тэрбум төгрөгөөр буюу татварын бус орлогод эзлэх жин нь 3.1 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм.

2.4. Улсын төсвийн орлого нь уул уурхайн салбараас тэр дундаа экспортод гаргаж байгаа эрдсийн түүхий эд (зэсийн баяжмал болон нүүрс, алт)-ийн биет хэмжээ болон дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай байгаа нь төсвийн орлогыг тогтвортой бүрдүүлэхэд эрсдэл дагуулсан хэвээр байна. Ирэх онд нүүрсний экспортыг 90 сая тн, зэсийн баяжмалын экспортыг 1.9 тн-д хүргэх зорилт тавьж, нүүрсний зах зээлийн үнийг тн тутамд 70 ам.доллар, зэсийн зах зээлийн үнийг 9,700 ам. доллараар тооцжээ. Олон улсын байгууллага, шинжээчдийн таамаглалаар 2026 онд дэлхийн зах зээлд нүүрсний үнэ ерөнхийдөө тогтвортой байх төлөвтэй байгаа бөгөөд дэлхийн хэрэглээ, олборлолтын бууралтаас үүдэн үнэ буурах, нийлүүлэлтийн илүүдэл үүсэх хандлага үргэлжилсээр байгаа ч таамаглал нүүрсний төрөл, бүс нутгаас хамаарч харилцан адилгүй байна.


Зураг 4. Түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ



Эх сурвалж: <https://www.worldbank.org/en/research/commodity-markets#>

Эрчим хүчний нүүрсний үнэ 2026 онд эрэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор бага зэрэг өсөх магадлалтай байгаа бол харин коксжих нүүрсний үнэ бага зэрэг буурах төлөвтэй байна. Ирээдүйн үнэд нөлөөлөх гол хүчин зүйлс нь дэлхийн гангийн эрэлт, Австрали зэрэг томоохон үйлдвэрлэгчдийн нийлүүлэлтийн хязгаарлалт, Хятад зэрэг хэрэглэгч орнуудын бодлогын өөрчлөлт зэргээс хамаарч байна. Манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох коксжих нүүрс зөвхөн Хятад улс руу гарч байгаа учраас тус улсын эдийн засгийн нөхцөл байдал нүүрсний экспортод гол эрсдэлийг дагуулж байна.


Зураг 5. Эрдсийн түүхий эдийн үнэ



Эх сурвалж: <https://www.worldbank.org/en/research/commodity-markets#>

2.5. Төсвийн орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого дийлэнх хувийг эзэлж байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг ДНБ-д харьцуулж үзвэл 2018 онд 29.1 хувь, улмаар 2021-2024 онд 30.2-37.1 хувийг тус тус эзэлж байсан бол 2025 онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 33.6 хувь, 2026 оны төсвийн төсөлд 30.9 хувь байхаар төлөвлөжээ. Татварын орлогыг 29.7 их наяд төгрөг буюу 2025 оны тодотголоор батлагдсан дүнгээс 1.4 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж тооцсон байгаа бөгөөд үүнээс орлогын албан татвараас орох орлого 9.2 их наяд төгрөг буюу энэ оноос 626.4 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын шимтгэл, хураамжаас орох орлого 6.7 их наяд төгрөг буюу энэ оноос 705.5 тэрбум төгрөгөөр, Нэмэгдсэн өртгийн албан татвараас орох орлого 7.0 их наяд төгрөг буюу 386.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт дүнгээр татварын орлогын 77.4 хувийг бүрдүүлж байна.


Зураг 6. Улсын төсвийн 2018-2026 оны татварын ба татварын бус орлогыг ДНБ-д харьцуулсан харьцаа, хувиар



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны Төсвийн төслийн танилцуулгын тоо, баримт

Орлогын албан татвар өмнөх оноос 626.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн гол шалтгаан нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 450.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Зураг 7. Төсвийн 2018-2026 оны татварын орлого, татварын төрлүүд, ДНБ-д эзлэх хувиар




Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны Төсвийн төслийн танилцуулгын тоо, баримт

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын дийлэнх хувийг Орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар эзэлж байсан. Уул уурхайн салбарын мөчлөгөөс хамааралтайгаар төсвийн орлогын эмзэг байдал өндөр хэвээр байгаа өнөөгийн нөхцөлд уул уурхайн бус салбараас төсөвт орох орлогыг нэмэгдүүлэхэд татварын бодлогыг чиглүүлэх, уул уурхайн бус салбарын үйлдвэр, үйлчилгээг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн үйлдвэрлэл, гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татварын бодлогоор дэмжих, татварын бааз суурийг өргөтгөх бодлогыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх замаар төсвийн тогтвортой орлогыг бий болгох зайлшгүй шаардлага тулгарч байна.

2.6. Татварын зарлагыг бууруулах, багасгах шаардлагатай. Татварын хэт олон хөнгөлөлт, чөлөөлөлтийг эргэн харж, хөнгөлөлт, чөлөөлөлт бүрийн зорилго, үр дүнг тооцон эдийн засгийн үндэслэлийг авч үзэн Засгийн газар, УИХ-ын түвшинд нарийвчлан судалж, холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах замаар бага хувиар ч гэсэн татвар ногдуулах орлогыг тодорхойлох замаар татварын бааз суурийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй.

Зураг 8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, тэрбум төгрөгөөр, нийт төсвийн орлогод эзлэх хувиар, 2023-2026 он



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны Төсвийн төслийн танилцуулгын тоо, баримт


2.7. Татварын багц хуулийн өөрчлөлтийг дунд болон урт хугацааны төсвийн бодлоготой нийцүүлэх хэрэгтэй байна. Засгийн газраас татварын багц шинэчлэлийг хэрэгжүүлэх гэж байгаа нь төсвийн орлого, орлогын бүтцэд шууд нөлөөлнө. Энэхүү

өөрчлөлтөөс эдийн засагт болон татварын орлогод үзүүлэх нөлөөллийг тооцохын зэрэгцээ дунд хугацаанд төсвийн орлого, зарлагын хосолсон бодлогын шинэчлэлийн хэрэгжүүлэх шаардлагатай.

3. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ТАЛААР

3.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн өсөлт 2025, 2026 онд саарах хандлага ажиглагдаж байна. Нэгдсэн төсвийн нийт зарлага, цэвэр зээлийн дүн өмнөх оноос 2021 онд 21.4, 2022 онд 16.2, 2023 онд 24.0, 2024 онд 35.9 хувиар буюу урьд жилийн өсөлтөөс 50 орчим хувиар илүү огцом өсөж байсан юм. Дэлхийн эдийн засаг, геополитикийн нөхцөл байдал, эрдэс баялгийн дэлхийн зах зээл дэх үнийн бууралт зэрэг эдийн засагт учирч буй гадаад, дотоод эрсдэлт хүчин зүйлсээс шалтгаалан төсвийн зарлагыг 2025 онд 3.2, 2026 онд 4.5 хувиар өснө гэж тооцоолжээ.


Зураг 9. Нэгдсэн төсвийн 2018-2026 оны нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн харьцуулалт, тэрбум төгрөг



Монгол Улсын нэрлэсэн ДНБ-ий өсөлт 2024 онд төсвийн зарлагын өсөлтөөс 2.7 дахин бага байсан бол 2025 онд 3.9, 2026 онд 3.1 дахин өндөр болж байгаа нь эерэг хандлага юм.

3.2. Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулахаар төлөвлөсөн байна. ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлагын хэмжээ 2018 онд 29.0, 2019 онд 31.6, 2020 онд 37.6, 2021 онд 37.1 хувь болж өссөн бол 2022 онд 33.9, 2023 онд 29.2 хувь болж буурсан ч 2024 онд дахин 38.3 хувьд хүрч өсөөд 2025 онд 35.1 хувь болох хүлээлттэй, 2026 онд 32.2 хувь болж багасна гэж төсөвлөжээ.

Зураг 10. Эдийн засаг дахь төрийн оролцоо буюу ДНБ-д төсвийн нийт зарлагын эзлэх хувь



Энэ нь эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах бодлогын зөв эхлэл юм. Цаашид төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг зохистой түвшинд хүртэл бууруулан энэ хандлагыг үргэлжлүүлэх шаардлагатай.

3.3. Төсвийн бодлогын зорилтуудыг холбогдох баримт бичгүүдэд харилцан уялдаатай тодорхойлсон боловч төсвийн зарлага, үр дүнгийн үзүүлэлтүүдийн нийцлийг бүрэн хангаагүй байна. Засгийн газраас 2026 оны төсвийн төслийг “Таны төлсөн татварыг-Таны саналаар-Хөгжингүй Монголын ирээдүйн төлөө” зарчимд тулгуурлан боловсруулахдаа макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төрийн оролцоог бууруулах төсвийн бодлогын зорилтыг эдгээр баримт бичгүүдэд харилцан уялдаатай тусгасан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026-2028 оны ТХМ-ийн төсөл, 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын тэргүүлэх чиглэл, 2026 оны төсвийн төсөлд дэвшүүлсэн төсвийн бодлогын зорилтууд ба хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд, хүрэх түвшин, жилийн төсвийн уялдаа, хамаарлыг харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Төсвийн баримт бичгүүдэд тусгагдсан төсвийн бодлогын зорилтуудын уялдаа

Баримт бичиг	Гол зорилт	Төсвийн бодлогын уялдаа, нийцэл
Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026-2028 оны ТХМ-ийн төсөл	Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засаг дахь төрийн оролцоог үе шаттай бууруулж, хувийн хэвшлийн бизнес тэлэх орон зайг нэмэгдүүлэх, эдийн засгийн салбаруудын бүтээмжийг дэмжих чиглэл баримтална.	Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төрийн оролцоог бууруулах чиглэл нь 2026 оны хөгжлийн төлөвлөгөө болон төсвийн төсөлтэй уялдсан байна.
Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө	“Хүн төвтэй” хөгжлийн үзэл санаанд нийцсэн “эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох”-ыг зорьж, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлнэ.	УИХ-аар батлагдсан жилийн хөгжлийн төлөвлөгөөний зорилго нь бүтцийн шинжтэй өөрчлөлт буюу реформд чиглэж байгаа нь 2026-2028 оны ТХМ-ийн төсөл болон 2026 оны төсвийн төсөлд дурдсан зорилтыг бодлогын хүрээнд өргөтгөж, хэрэгжүүлэх суурь болж өгсөн байна.
Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл	Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, төсвийн зардлын өсөлтийг хязгаарлаж, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж хувийн хэвшлийг дэмжихийн зэрэгцээ олон нийтийн саналд үндэслэн эрүүл мэнд, боловсролын салбарт түлхүү анхаарна.	Засгийн газраас боловсруулсан 2026 оны төсвийн төсөл нь 2026-2028 оны ТХМ-ийн төсөл болон жилийн хөгжлийн төлөвлөгөөний зорилтыг төсөв, санхүүгийн хувьд хэрэгжүүлэх нөхцөлийг тодорхой болгож, нийгмийн салбарын урсгал зардлын санхүүжилт, хөрөнгө оруулалтаар өргөтгөсөн байна.

Дунд хугацааны ТХМ, жилийн хөгжлийн төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төслийн хувьд бодлогын уялдааг хангасны зэрэгцээ эдийн засгийн эрх чөлөөг чухалчилж, төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшлийг дэмжих зорилт дэвшүүлсэн нь агуулгын хувьд нэг чиглэлд төвлөрчээ.

3.4. Төсвийн төсөлд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарыг онцолсон нь 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний “хүн төвтэй” хөгжлийн үзэл санаатай уялдаж байна. Төсвийн тухай хуулийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх” гэж заасны дагуу нийт төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь болон зорилтот түвшин, бодлогын үндэслэлийг тогтоон, шаардагдах санхүүжилтийн хэмжээг тооцож гаргажээ. Гэхдээ жилийн хөгжлийн төлөвлөгөөнд дурдсан реформын зорилтуудыг хэрэгжүүлэх санхүүжилт төсвийн төсөлд бүрэн тусгаадаагүй, ТХМ ба хөгжлийн төлөвлөгөөнд тавьсан зорилтуудыг 2026 оны төсвийн төслийн 1 дүгээр хавсралт болох ТЕЗ-дын хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй хэрхэн уялдуулсан нь тодорхойгүй байна.


3.5. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан ТЕЗ-дын 61 тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлэх 316 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулах дүн нь 2026

оны төсвийн зарлагаас хэт өндөр байна. Төсвийн бодлогын зорилтуудын хэрэгжилтийг ТЕЗ-дын зарлагын хөтөлбөрөөр дамжуулан жил бүрийн төсөвт тусган төлөвлөдөг. Нийт 36 ТЕЗ-ийн нийт 97 хөтөлбөр, 215 үр дүн, 397 шалгуур үзүүлэлт, тэдгээрийн зорилтот түвшнийг тодорхойлон 2026 онд хэрэгжүүлэхээр төсөвлөжээ. Шалгуур үзүүлэлтүүдийг чанарын (үйлчилгээний хүртээмж, үр нөлөө) ба тоо хэмжээний (бүтээн байгуулалтын тоо, хөрөнгө оруулалтын хэмжээ) гэсэн хослолоор тогтоосон байна. Ийнхүү жилийн хөгжлийн төлөвлөгөө, төсөв, зорилтот түвшнийг уялдуулах нь бодлогын зорилт, зарлагын хөтөлбөр, шалгуур үзүүлэлт, жилийн төсвийн уялдаа холбоо сайжирч, гүйцэтгэлийн үр дүнг хэмжих боломж нэмэгдэх давуу талтай. Харин төсвийн үйл явцад иргэдийн санал, олон нийтийн оролцоо нэмэгдэж байгаа ч төсвийн сахилга бат, өрийн тогтвортой байдлыг хангах бодлогыг баримталснаар шинэ бодлого, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх боломж хязгаарлагдах төдийгүй бодлогын зорилт, төсөв, үр дүнгийн гинжин холбоо тасалдах эрсдэлтэй байна.

3.6. Засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэл нь нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн салбар, эдийн засгийн үйл ажиллагаа байна. Нэгдсэн төсвийн 2026 оны нийт зарлагад Төсвийн ерөнхийлөн захирагч нарын зардлын эзлэх хувийг тооцож үзэхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын зардал 28.4, Эрүүл мэндийн сайдын зардал 10.3, Боловсролын сайдын зардал 10.9, Сангийн сайдын зардал 10.5, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал 19.0 хувь буюу нийт зарлагын 79.2 хувийг эзэлж байна. Төсвийн урсгал зардлын 82.0 хувийг мөн эдгээр ТЕЗ нарын зардалд зарцуулж байгаа юм. Энэ нь дэвшүүлж буй төсвийн бодлогын зорилт нь төсвийн зарлагад тусгалаа олж буй хэдий ч Монгол Улс нийгмийн халамж, хамгааллын улс болсныг илтгэнэ.

3.7. Урсгал зардлын бүтцэд татаас, урсгал шилжүүлгийн зардал 50-аас илүү хувийг эзэлж байгаа нь анхаарал татахуйц асуудал болоод байна. Нэгдсэн төсвийн 2018-2025 оны нийт зарлагын дунджаар 76.0 хувийг урсгал зардал эзэлдэг байсан бол 2023 оноос эхлэн буурч 2026 онд 74.4 хувьд хүрэхээр тооцжээ. Урсгал зардлын дүнд бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь сүүлийн 3 жилд буурч байгаа хэдий ч цалин хөлсний зардлын эзлэх хувь өсөж байгаа юм. Энэ нь цаашид төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн бусад зардлыг нэмэх орон зайг хязгаарлаж байна.

Зураг 11. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018-2026 оны урсгал зардлын бүтэц, хувиар




Урсгал зардал зээлийн үйлчилгээний төлбөрийн эзлэх хувь өөрчлөлт багатай байгаа бол урсгал зардалд татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувиас 10 гаруй хувиар өндөр болж, 51.3-54.8 хувьд хүрч нэмэгдэж буй нь анхаарах татах асуудал болоод байна.

3.8. Улсын төсөв ба орон нутгийн төсөв хоорондын одоогийн харилцааг шинэчлэх замаар Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах шаардлагатай. Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгаснаар Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагыг тооцон аймгуудад олгох санхүүгийн дэмжлэгийг 297.5 тэрбум төгрөгөөр тооцсоноор өмнөх оноос 24.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол аймаг, нийслэлээс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 1,430.7 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 372.8 тэрбум төгрөгөөр бууруулж тооцжээ. Орон нутгийн төсвийн ашиг/алдагдлын аргачлалаар хийгдэж буй өнөөгийн санхүүгийн дэмжлэг буюу шилжүүлгийн тогтолцоог өөрчлөн төрөөс явуулж байгаа Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах нэн шаардлагатай байна. Энэ талаар Дэлхийн банкны судалгаанд³ мөн дурдагдсан байгаа. Өнөөгийн улсын төсвөөс орон нутгийн төсөвт өгч байгаа төсвийн санхүүгийн дэмжлэг/шилжүүлгийн тогтолцоог Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгодог аргачлал шиг загвар, томьёонд суурилан тооцож олгодог байх төсөв, санхүүгийн эрх зүйн зохицуулалтын шинэчлэлтийг хийж нэвтрүүлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлага, эдийн засгийн чадавх, нөөц боломж, хүн ам, газар нутгийн хэмжээ, төвөөс алслагдсан байдал, уур амьсгалын нөхцөл, суурьшил зэрэг хүчин зүйлсийг оруулан тооцдог байх нь чухал юм.

4. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР

4.1. Төсвийн хөрөнгө оруулалтыг эрэмбэлэж төлөвлөх тогтолцоог зохистой хэрэгжүүлэхгүй байгаа нь үр дүн, үр өгөөжийг бууруулж байна. Монгол Улсын ДНБ 2005 онд 2.5 тэрбум ам.доллартай тэнцэж байсан бол түүнээс хойш 20 жилийн дотор 10 дахин нэмэгдэж, 25.3 орчим тэрбум ам.долларт хүрээд байна. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтад зарцуулсан хөрөнгийн тоон мэдээллээс үзвэл одоогоос 10 жилийн өмнө 2015 онд 1,396.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал гаргаж байсан. Харин 2025 онд 8,885.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Зураг 12. Улсын төсвийн хөрөнгийн зардал (сая төгрөг)



Сүүлийн 10 жилийн хугацаанд улсын хөрөнгө оруулалтын зардал 6 дахин нэмэгджээ. Үүнээс үзвэл, 2014-2015 онд хөрөнгө мөнгөний дутагдалтай, төсөв хүрэлцээгүй байгаагийн улмаас шийдвэрлэгдээгүй хөрөнгө оруулалтын асуудлуудыг өнгөрсөн хугацаанд шийдвэрлэх боломжтой байжээ. Ийнхүү ихээр өсөн нэмэгдсэн хөрөнгө оруулалтын зардал

³ Дэлхийн банк: Монгол Улсын Төсвийн судалгаа 2025 оны 6 дугаар сар. 29 дүгээр хуудас.

дотор нэг салбарыг орхигдуулж, нөгөө салбарт хэт түлхүү хуваарилсан төслүүд, оновчтой бус, хэт өндөр өртөг зардалтай барилга объект олон тусгагдаж ирснийг Үндэсний аудитын газраас өгсөн дүгнэлт болон судлаачдын гаргасан тоо, баримтуудаас тодорхой харж болохоор байна.

Үндэсний аудитын газраас 2025 оны 5 дугаар сард гаргасан “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” сэдэвт аудитын тайланд тусгагдсан дүгнэлт, санал өнөөдөр ч хүчинтэй хэвээр, уг дүгнэлтэд тусгагдсан анхаарах, залруулах ёстой асуудлууд өнөөг хүртэл тулгамдсаар байна. ҮАГ-ын аудиторуд, шинжээчдийн боловсруулан гаргасан дээрх дүгнэлтэд:

- Улсын төсвийн төсөвлөлтийн шаардлагад нийцүүлэх, нэн тэргүүний хэрэгцээнд суурилан эрэмбэлж төлөвлөх тогтолцоог орхигдуулсан нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний цар хүрээ, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан барилга байгууламжийн 52.8 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна гэж дүгнэсэн байдаг⁴.

4.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, үнэлэх, эрэмбэлэх тогтолцоо, дүрэм журамд алдаа дутагдал, сул тал олон байна. Тухайлбал:

- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөх, үнэлэх, эрэмбэлэх журам”-ыг тус тус батлан мөрдүүлж ирсэн. Эдгээр журамд төсвийн ерөнхийлөн захирагчид Сангийн яаманд дараа оны төсвийн саналыг боловсруулж ирүүлэхдээ шинээр хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашгийн тооцооллыг хийсэн байх үүрэгтэй гэж заажээ. Гэвч энэ жил ТЕЗ-аас Сангийн яаманд ирүүлсэн төсвийн саналуудыг үзэхэд эдийн засгийн үр ашгийн нарийвчилсан шинжилгээ, тооцоолол хийсэн ТЕЗ байхгүй байна.
- Тогтоол, тушаалд заасанчлан эдийн засгийн шинжилгээ, тооцоолол хийгээгүй төслийг Сангийн яам хүлээн аваад 30 гаруй хоногийн дотор бүхий л төслүүдийг зөв оновчтой үнэлэх, эрэмбэлэх боломжгүй юм.

Ийм ч учраас жилээс жилд ач холбогдол багатай, оновчгүй хөрөнгө оруулалтын төсөл төсөвт тусгагдах, төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөв, зардал, гүйцэтгэлийн явцад ихээхэн хэмжээгээр өсөн нэмэгдэх тохиолдол дахин дахин гарсаар байна. Анх төслийг төлөвлөж, хүлээн авахдаа эдийн засгийн үр ашгийн тооцоолол үнэлгээг хийгээгүй, хийсвэр, үндэслэл муутай тооцоолол бүхий төсвийн төслийг Засгийн газар, УИХ-д өргөн барьж хэлэлцүүлсний төлөө тухайн ТЕЗ нар ямар ч хариуцлага хүлээхгүй явж ирсний улмаас энэ байдал жилээс жилд даамжирч өртөг нь өсөн нэмэгддэг барилга, объект, нэмэгдсэн төсөвт зардлын дүн ихээхэн өсөн нэмэгджээ.

4.3. Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг ДНБ-тэй харьцуулсан харьцааг сүүлийн 5 жилд авч

⁴ ҮАГ, Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

үзвэл 3-5 хувийн хооронд хэлбэлзэж байгаа нь хөгжиж байгаа орнуудын 4-8 хувийн түвшинтэй ойролцоо байна. Манай орны хувьд төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ хэвийн түвшинд байгаа боловч төсвийн хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засгийн үр ашгийг авч үзэхэд хөрөнгө оруулалтын төслүүд анх ашиглалтад орох төлөвлөсөн хугацаанаас ихээхэн хоцордог, анхны төсөвт өртөг их хэмжээгээр нэмэгддэг, хөрөнгө оруулалтын ач холбогдлыг эрэмбэлэх тал дээр учир дутагдалтай байх гэх мэт асуудлууд байгааг анхаарах нь зүйтэй.

4.4. Хүн амын өсөлтөд суурилсан урт хугацааны төлөвлөлттэй төсвийн хөрөнгө оруулалтыг уялдуулах хэрэгтэй. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёлын салбарт ирэх жилүүдийн зорилтыг тодорхойлж, төсвийг төлөвлөхөд нийт улсын болон тухайн аймаг, хот, сум, дүүргийн хүн амын өсөлтийн төсөөлөл, тооцоолол үндсэн суурь үзүүлэлт болдог. Зарим тохиолдолд өнгөрсөн жилүүдэд гаргаж байсан хүн амын өсөлтийн төсөөлөл бодит байдлаас зөрж байгаа тул цаашид хүн амын өсөлтийн төсөөллийг 10 жилээс гадна, 5 таван жилээр илүү магадлал сайтай тооцоолон гаргаж байх шаардлагатай байна.

4.5. Хөрөнгө оруулалтын зохицуулалтын орчин, үр дүнгийн үнэлгээ хийж, сайжруулах хэрэгтэй. Өнгөрсөн жилүүдэд батлан мөрдүүлж байгаа хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хуваарилалт, санхүүжилтийн журмыг анхааралтай судалж, шинэчлэн боловсруулах, Төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын төслийн эдийн засгийн үнэлгээ, шинжилгээг аль түвшинд, аль байгууллага, хэрхэн хийж байх, шинээр боловсруулж төсөвт тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагын талаар тодорхой заалтыг нэмж тусгах, Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг анхан шатны шууд захирагч, аймаг, сумаас эхлэн УИХ-д өргөн баригдах түвшинд хүртэл бүхий л үе шатуудыг анхааралтай судлан үзэж, оршиж байгаа алдаа дутагдлыг илрүүлэн, түүнийг засаж сайжруулах, төслийн менежментийн талаарх тодорхой арга, аргачлалуудыг шингээж өгөх шаардлагатай.

4.6. Хөрөнгө оруулалтын явцын ил тод байдал, хяналтыг сайжруулах нь үр дүнг нэмэгдүүлнэ. Хөрөнгө оруулалтын төслийн явцын хяналт, шалгалтыг эрс сайжруулж, үүнд захиалагч, гүйцэтгэгчээс гадна бусад талууд, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.

5. ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР, ТӨЛБӨРИЙН ТАЛААР

5.1. Засгийн газрын өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа сүүлийн жилүүдэд тогтвортой буурч байгаа боловч өрийн нийт дүнд гадаад өрийн эзлэх хувь өндөр хэвээр байгаа нь дунд болон урт хугацаанд төсөвт үзүүлэх өрийн эрсдэл хэвээр байгааг илтгэнэ. Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 35.5 их наяд төгрөг буюу ДНБ-ний 39.5 хувьтай тэнцэж байна. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 44.5 хувь, 2026 оны төсөөллөөр 43.8 хувьтай тэнцэхээр байна⁵.

Өнгөрсөн жилүүдэд Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл буурч, төсвийн тэнцэл ашигтай гарч, гадаад өрийн үндсэн төлбөрийг төлөх нөхцөлийг бүрдүүлж, энэ нь Засгийн газрын өрийн тогтвортой байхад чухал нөлөө үзүүлж байсан боловч өнөөгийн гадаад эдийн засгийн орчны тодорхойгүй байдал буюу гадаад шок, гадаад валютын хэлбэлзэл (Засгийн газрын гадаад зээлийн өрийн үлдэгдлийн 53.7 хувь нь ам.доллараар)⁶, төсвийн орлогын бууралт, төсвийн алдагдал, төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ, орон нутгийн гадаад үнэт цаасны

⁵ Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн товч танилцуулга"-ын 32-33-р хуудас.

⁶ Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн товч танилцуулга"-ын 34-р хуудас.

үлдэгдэл, Хөгжлийн банкны өр, их хэмжээний болзошгүй өр төлбөрүүд нь дунд болон урт хугацааны өрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлүүдийг дагуулж байна⁷.

5.2. Засгийн газрын гадаад өрд эзлэх гадаад үнэт цаас болон гадаад зээл, өрийн баталгааны дүнгийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа нь Засгийн газрын өрийн үлдэгдэл өсөхөд нөлөөлж, Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад эрсдэл дагуулж байна. Засгийн газрын бусад өр 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 6.4 их наяд төгрөг байгаа бол 2026 оны төсвийн төслөөр 10.3 их наяд төгрөг болохоор байна. Үүнд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь Засгийн газрын өрийн баталгаа 3.9 их наядаар нэмэгдэж байгаатай холбоотой юм. БНХАУ-ын Хөгжлийн банкнаас Монгол Улсын Хөгжлийн банкны авч ашигласан 352.7 сая юаны зээл, Нийслэлээс олон улсын зах зээлд гаргасан 500 сая ам. долларын үнэт цааснууд нь Засгийн газрын баталгаа цаашид эрсдэлд нөлөөлөх хүчин зүйл болно.

5.3. Засгийн газрын өрийн үйлчилгээ ирэх жилүүдэд нэмэгдэх хандлагатай байгаа нь Засгийн газрын төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх үр дагаврыг бий болгож болзошгүй байна. Засгийн газрын өрийн үйлчилгээ буюу гадаад, дотоод бонд, гадаад зээлийн үндсэн өрийн хүүгийн төлбөрийн дүн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2.8 их наяд төгрөг байгаа бөгөөд 2026 онд 879 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 3,748.8 тэрбум төгрөг болохоор төсвийн төсөлд тусгагджээ. Ирэх онд зөвхөн гадаад зээлийн үндсэн өрийн төлбөрт 1,467.0 тэрбум төгрөг, гадаад бондын үндсэн өрийн төлбөрт 656.6 тэрбум төгрөг, гадаад зээлийн хүүгийн төлбөрт 671.8 тэрбум төгрөг, гадаад бондын хүүгийн төлбөрт 560.2 тэрбум төгрөг, нийт 3,355.6 тэрбум төгрөг төлөхөөр байгаа нь улсын төсвийн зарлагын 10.2 хувь, ДНБ-ний 3.2 хувьтай тус тус тэнцэж байна. Энэ дүнд төсвийн төсөлд танилцуулснаар дахин санхүүжилт болон, орон нутгийн үнэт цаасны өрийн үйлчилгээний дүн ороогүй болно. Эндээс харахад зөвхөн гадаад бондын үндсэн өр болон хүүгийн төлбөрт ирэх онд 1.2 их наяд төгрөг хүлээгдэж байгаа нь төсвийн орлого буурах тохиолдолд төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхөөр байна.

5.4. Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2.5 тэрбум ам.доллар буюу 9.0 их наяд төгрөг байгаа нь Засгийн газрын нийт гадаад өрийн 38.5 хувийг арилжааны гадаад үнэт цаасны үлдэгдэл эзэлж байгааг харуулж байна. Олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас авсан хөнгөлөлттэй зээл болон гадаад зах зээлээс бүрдүүлсэн үнэт цаасны эх үүсвэрээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн эдийн засгийн үр ашгийг нарийвчлан дахин хянаж, тухайн төслийг хэрэгжүүлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хийгдсэн дамжуулан зээлдүүлэх гэрээний төлбөрийг төсөвт дарамт учруулахгүйгээр гүйцэтгэж валютын ханшны ашиг/алдагдлыг тухай бүр тооцож байх шаардлагатай.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөөр 2026 оны төсвийн жилд нийт 564.3 тэрбум төгрөг төсөвт төвлөрөхөөр байгаа хэдий ч улсын төсвөөс гадаад зээлийн өрийн үйлчилгээний төлбөрт 3.3 их наяд төгрөг, үүнээс зөвхөн гадаад зээлийн хүүгийн төлбөрт 671.8 тэрбум төгрөг төлөхөөр байна⁸.

⁷ Дэлхийн банк: Монгол Улсын Төсвийн судалгаа 2025 оны 6 дугаар сар. 9 дүгээр хуудас.

⁸ Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн товч танилцуулга"-ын 34-р хуудас.

6. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТАЛААР

Эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хамрах хүрээ хэт өргөн байгааг хязгаарлах шаардлагатай. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд эрүүл мэндийн даатгалын санд 2026 онд орох нийт орлогыг 2,551.8 тэрбум төгрөг, нийт зарлагыг 2,273.3 тэрбум төгрөг байхаар тооцон тусгажээ. Үүний дотор төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн төлөх шимтгэлд улсын төсвөөс 431.2 тэрбум төгрөг, төр хариуцах тусламж үйлчилгээнд 881.6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгажээ. Өнгөрсөн жилүүдэд эрүүл мэндийн даатгалын сангийн орлого хангалттай бүрэлдэхгүй байгаа, нөгөө талаар улсын төсвөөс хариуцах зардлын ачаалал маш их байгаатай холбоотой эрүүл мэндийн даатгалын сан алдагдал ихтэй, эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтээ цаг хугацаанд нь бүрэн авч чадахгүй байх нөхцөл үүссээр байгаа билээ. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1 заалтад Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийн хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлийг заасан, хуулийн 9.1.1 заалтад “хэвтэн эмчлэх тусламж, үйлчилгээ”-ний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн хариуцахаар заасантай холбоотой гэж үзэж байна.

Иймээс Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.1 заалтыг цаашид илүү тодорхой болгох, 0-18 насны хүүхэд, багачууд, өндөр настанд хуулийн энэ заалт бүрэн үйлчлэх, харин 18-60 хүртэлх насны иргэдэд тодорхой нөхцөлтэй, хязгаартайгаар зардлыг нь хариуцдаг байхаар нэмэлт зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 18-60 хүртэлх насны иргэний эмчилгээний зардлыг даатгалын сангаас гаргадаг байх, харин эмнэлгийн ор хоног ашигласан, хоол цайны мөнгийг эмчлүүлж буй иргэн өөрөө хариуцдаг байхаар өөрчилж болохоор байна. Ийм зохицуулалтыг хийснээр зайлшгүй шаардлагатай бус нөхцөлд хэвтэн эмчлүүлэх сонирхолтой иргэдийн тоо цөөрөх, улмаар өдрийн эмчилгээг илүү түлхүү хөгжүүлэх нөхцөл боломж бүрдэх болно.

7. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

7.1. Тэтгэврийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын тэтгэвэр авч байгаа иргэдийн дийлэх нь тэтгэврийн доод хэмжээний түвшинд тэтгэвэртэй, тэтгэврийн зээл амжиргааны гол эх сурвалж болж байгаа нь тогтолцооны гажуудал юм. Үүнээс гадна тэтгэврийн санд төсвөөс олгох татаас 2018 онд 594.9 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 1,447.4 тэрбум болж нэмэгдсэн, үүнийг 2026 онд хэвээр хадгалахаар царцаасан нь тэтгэврийн сангийн өсөлтөөс хамаарах төсвийн татаасыг санхүүжүүлэх боломж хязгаарлагдаж байгааг харуулж байна. Энэ алдагдал нь цаашид улам нэмэгдэж тэтгэврийн сан тогтолцооны хувьд хүндрэх нөхцөл болж байна. Монгол Улс тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх бодлогыг 2000 оноос хэрэгжүүлэхээр оролдож хоёр удаа төрөөс баримтлах бодлогыг баталсан байдаг. Түүнчлэн Алсын хараа-2050 хөгжлийн бодлогод урт хугацаанд бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих, хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх зэрэг олон зорилтыг тусгасан байдаг. Гэвч эдгээр ажлууд нь эхлэл төдий байгааг анхаарч тэтгэврийн шинэчлэлийг түргэсгэх нь тэтгэврийн тогтолцооны үндсэн зорилгыг хэрэгжүүлэх, төсөвт ирэх урт хугацааны санхүүгийн ачааллыг бууруулах ач холбогдолтой гэж үзэж байна.

7.2. Тэтгэврийн даатгал, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангууд улсын төсвөөс татаастай ажиллахаар байна. 2026 оны төсвийн төсөлд тусгагдсанаар Нийгмийн даатгалын сангуудаас Тэтгэмжийн даатгалын сан,

Ажилгүйдлийн даатгалын сангийн тэнцэл ашигтай гарч, Тэтгэврийн даатгалын сан, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан улсын төсвөөс татаас авахаар байна. Ирэх оны төсвийн төслөөр Тэтгэмжийн даатгалын сан 320.6 тэрбум төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сан 183.7 тэрбум төгрөгийн зарлагатай ажиллаж орлого, зарлагын тэнцлээрээ ашигтай ажиллахаар байна. Тэтгэврийн даатгалын сангийн тухайд 5.9 их наяд төгрөгийн зарлагатай гарч тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд төсвөөс 1.48 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор байна.

7.3. Тэтгэврийн даатгалын эрх зүйн орчны шинэчлэл удаашралтай байна. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийн талаар 2025 онд хийсэн судалгааны тайлангаас харахад хэрэв тэтгэврийн даатгалын шинэчлэлийг нэн даруй хийхгүй бол улсын төсвөөс тэтгэврийн даатгалын санд өгөх татаас санхүүжилт жил болгон ойролцоогоор 400.0 гаран тэрбум төгрөгөөр өсөж 2030 он гэхэд энэ санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь 3.2 хувьд хүрч төсөв энэ ачааллыг даахаа болино гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг. Гэтэл энэ шинэчлэл удааширч 2023 оны шинэчлэлийн хүрээнд хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын хуулийг батлалгүй орхисон нь асуудлыг улам даамжруулж байна. Иймд Нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэлийн багц хуулиудаа өргөн барих, хэлэлцүүлэх асуудлыг анхаарах шаардлагатай.

8. ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТАЛААР

8.1. Үндэсний баялгийн санг тогтолцооны хувьд сайжруулах шаардлагатай. 2024 онд батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд “4.1.3. “төрөлжсөн сангийн үйл ажиллагааны удирдлага” гэж төрөлжсөн сантай холбоотой Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, төрөлжсөн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах төрийн захиргааны төв байгууллагыг” гэж, “4.1.4. “Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого” гэж санхүүгийн жилийн макро-эдийн засгийн орчин, мөнгөний бодлоготой уялдуулан гаргасан хөрөнгө оруулалтын хэрэгслийн үр өгөөжийн доод хэмжээ болон эрсдэлийн дээд хэмжээний жишиг үзүүлэлтийг тогтоосон хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийг;” хэмээн сангийн удирдлагыг хэрэгжүүлэх гол зохицуулалтыг тусгасан нь тогтолцооны эхлэл байсан хэмээн үзэж байна. Иймд сангийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, бодлогыг тодорхой болгох шаардлагатай байна.

8.2. Ирээдүйн өв сангийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг хайх хэрэгтэй байна. Ирээдүйн өв сангийн мөнгөн хөрөнгийн хуримтлал 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 1.3 тэрбум ам долларт хүрсэн бөгөөд уг хөрөнгийг гадаад улсуудын төв банкны хадгаламжид байршуулах гэрээг Монголбанктай байгуулж Франц, Английн төв банкнуудад дунджаар жилийн 4.3-4.4 хувийн хүүтэйгээр байршуулсан байна. Гэтэл нөгөө талдаа гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор хамгийн сүүлд гаргасан Засгийн газрын Сенчири-4 гадаад бондын хүү жилийн 6.625 хувь, Хөгжлийн банкны гаргасан гадаад бонд 8.5 хувь, Улаанбаатар хотын гаргасан гадаад бондын хүү 7.75 хувьтай байгаа юм. Хэдийгээр арайхийж хуримтлуулж бий болгосон хөрөнгийг эрсдэлээс хамгаалах нь зүйтэй боловч Ирээдүйн өв сангийн хөрөнгө оруулалтын өгөөж болон Засгийн газрын гадаад зээллэгийн хүү ийнхүү 2.25-4.1 хувийн зөрүүтэй байгаа нь анхаарал хандуулах асуудал мөн.

8.3. Үндэсний баялгийн сангийн бүрдүүлэлт хангалтгүй байна. Ирээдүйн өв сангийн АМНАТ-ын орлогыг 2025 оны төсвийн тодотголоор 1.26 их наяд төгрөг, хөрөнгө

оруулалтын орлогыг 138.1 тэрбум төгрөг гэж тус тус төлөвлөсөн боловч 8 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар АМНАТ-ын орлогын гүйцэтгэл 47.1, хөрөнгө оруулалтын орлогын гүйцэтгэл 33.2 хувьтай байна. Түүнчлэн Хуримтлалын сангийн ногдол ашгийн орлогыг 507.1 тэрбум төгрөг гэж төсөвлөсөн боловч 8 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 22.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

9. УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГОД НИЙЦСЭН ЭСЭХ

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д “УИХ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” гэж заасан байдаг. Энэ үүднээс УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь Үндэсний аюулгүй байдлын бодлогод хэр нийцэж буй талаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.1 дэх заалт, УИХ-ын Хяналт шалгалтын тухай хуулийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгсөн.

Хүснэгт 2. Төсвийн төсөл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн эсэх

ҮАБҮБ дахь заалтын дугаар	Заалтын агуулга	Тухайн заалтыг хэрэгжүүлж буй байдал
3.2.1.3	Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна.	-Уул уурхайн салбарын орлого 2005-2012 онд нэгдсэн төсвийн нийт орлогын 16 орчим хувийг бүрдүүлж байсан бол 2013-2019 онд 22 хувь, сүүлийн 5 жилд 31 хувь болж нэмэгдсэн. Энэ салбараас төсөвт төвлөрөх орлого 2025 онд 11,565.3 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт орлогын 31.4 хувь, тэнцвэржүүлсэн орлогын 34.1 хувийг эзэлж байсан бол 2026 онд 9,327.7 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцсон нь нэгдсэн төсвийн нийт орлогын 27 орчим хувийг бүрдүүлэхээр байна. Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 292.1 тэрбум, Ирээдүйн өв санд 2,186.9 тэрбум, улсын төсөвт 1,583.3 тэрбум төгрөг төвлөрүүлнэ. -Засгийн газраас нүүрсний олборлолт, төмөр замын тээвэр, хилийн боомтуудын дамжин өнгөрөх чадавхыг нэмэгдүүлэх, эрдсийн бүтээгдэхүүнийг уул уурхайн биржээр нээлттэй, ил тод арилжиж, олон улсын зах зээлийн үнээр борлуулахаар ажиллаж байна. -2026 оны төсвийн хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбар нь эрүүл мэнд, боловсрол, эрчим хүч байхаар тусгаж, хэдийгээр уул уурхайн салбарын орлого өнгөрсөн жилээс буурах хандлагатай байгаа ч боловсролын салбарт хөрөнгө оруулалтыг 2 дахин нэмэгдүүлж 1 их наяд, эрүүл мэндийн салбарт 5 дахин нэмэгдүүлж, 1.3 их наяд төгрөг хуваарилжээ.
3.2.1.9	Дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах замаар ядуурлыг арилгах тууштай бодлого хэрэгжүүлнэ.	-Засгийн газрын 2025 оны 158 дугаар тогтоолоор 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжилтний тоог нэмэгдүүлэх, багшийн ур чадвар, ажлын ачаалалд нийцүүлсэн цалин хөлсний бүтцийг бий болгох арга хэмжээг авахаар төлөвлөж байна. -Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх, тухайн салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэн төсвийн төсөлд тусгаж, дэд бүтцийн

		бүтээн байгуулалт төдийгүй түүнтэй холбоотой ханган нийлүүлэлт, үйлчилгээний салбарт шууд болон шууд бусаар нийт 109.6 мянган ажлын байр шинээр бий болох зорилт тавьжээ. -Үндэсний баялгийн сангийн хуримтлал өсөж, 2025 оны эхний 8 сарын байдлаар Ирээдүйн өв санд 4,706.1 тэрбум, Хуримтлалын санд 654.4 тэрбум төгрөг хуримтлагдаад байна. Ирэх онд Үндэсний баялгийн сан 2,956.1 тэрбум төгрөгөөр арвижих тооцоо гарсан бөгөөд иргэдийн орон сууцны санхүүжилтийн тогтвортой механизмтай уялдсан бодлогыг банк санхүүгийн тогтолцооны хүрээнд нэвтрүүлэх зорилт тавьсан. -2026 оны төсвийн төсөлд Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан нь өнгөрсөн жилийн түвшинд байна. -Үндэсний баялгийн сангийн тухай хуульд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэхээр заасныг хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан. Хууль батлагдсанаар иргэдийн өрхийн орлого, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, хөдөө, орон нутагт шилжин суурьшихад нь орон сууцны дэмжлэг үзүүлэх эрх зүйн боломж бүрдэнэ гэж үзэж байна. -Ирэх онд 0-18 хүртэлх насны нийт 1,332.8 мянган хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгоход 1,575.4 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд өрхийн амьжиргаанд бодитой дэмжлэг болно. Гэхдээ зөвхөн халамж, тэтгэмжээр ядуурлыг бууруулах боломжгүй юм. -Улсын хэмжээнд нийт 86 мянган иргэн хүнсний талон авч байгаа бөгөөд үнэхээр шаардлагатай боловч энэ арга хэмжээнд хамрагдаж чадахгүй иргэд цөөнгүй байгаа гэсэн судалгааны дүн бий.
3.2.2.2	Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална.	-Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын орох урсгал уул уурхайн салбар дахь эерэг хүлээлт, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлтийг даган огцом тэлж, 2011, 2012 онд тус бүр 5.7 тэрбум, 5.2 тэрбум ам.доллар буюу дунджаар ДНБ-ий 48.9 орчим хувьтай тэнцэж байв. Гэвч ГШХО-ын орох урсгалын хэмжээ жил тутам буурч ирсэн нь гадаад, дотоод эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдал, дэлхийн зах зээл дэх түүхий эдийн эрэлт, үнийн уналт голлон нөлөөлсөн байна. 2025 оны I улирлын байдлаар Монгол Улсад орсон ГШХО-ын үлдэгдэл 33,874.35 сая ам.доллар, үүнээс уул уурхайн салбарт 25,509.52 сая ам.доллар буюу 75.3 хувийг эзэлж байна. Улс орноор авч үзвэл хамгийн их нь Нидерланд 14,516.72 сая ам.доллар буюу 42.8 хувь, БНХАУ 5,465.91 сая ам.доллар буюу 16.1 хувь байгаа нь хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй тэнцвэртэй гэж үзэж болохоор байна. -Монгол Улс ЕАЭЗХ-ны орнуудад нийт 110.1 сая ам.долларын бараа экспортолж, 2.9 тэрбум ам.долларын бараа импортолсон нь манай улсаас экспортолж буй бараа сүүлийн 6 жилийн хугацаанд нийт экспортын ердөө 1 орчим хувийг эзэлж байгаа бол импортын 25-30 хувийг бүрдүүлжээ. Монгол Улс тус холбоотой чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулснаар хоёр талаас 375 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг харилцан татваргүй экспортлох боломж бүрдэнэ гэж тооцож байна. -Япон улстай 2016 онд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан нь тодорхой үр дүнд хүрээгүй нэг шалтгаан нь уг

		хэлэлцээрийг ашиглах хөрөнгө оруулалт орж ирээгүйгэй холбоотой. Тиймээс өнгөрсөн хугацаанд гаргасан алдаанаасаа сургамж авч дараа дараагийн хэлэлцээртээ анхаарч ажиллах, ялангуяа ЕАЭЗХ-ны чөлөөт худалдааны түр хэлэлцээр болон БНСУ-тай хийж байгаа эдийн засгийн түншлэлий хэлэлцээрт өмнөх алдааг давтахгүй байх нь чухал юм.
3.2.3.1	Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ.	-"Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогод "Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана" гэж заасан. Эдийн засгийн аюулгүй байдал гэдэг нь нэгдүгээрт, дотоод нөөц, бололцоогоо дайчилж, өөрийгөө тэтгэх, өсөн нэмэгдэх хэрэгцээг хангах чадвартай; хоёрдугаарт, гадаад, дотоод сөрөг хүчин зүйлийн эсрэг дархлаатай, тэдгээрийн үйлчлэлд эмзэг бус, өөрийгөө тэнцвэржүүлэх чадвартай байх явдал юм. Мөн дээрх баримт бичигт 2030 гэхэд "Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байх" зорилт дэвшүүлсэн. -2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,267.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэх бөгөөд энэхүү хөрөнгө оруулалт нь ДНБ-ий 5.8 хувийг бүрдүүлэх эдийн засгийн ач холбогдолтой төдийгүй эдийн засгийн өсөлтийг дэмжих, үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх, хэрэглээ, эргэлтийн хөрөнгийг идэвхжүүлэх чухал нөлөө үзүүлнэ гэж Засгийн газар тооцож байна.
3.2.3.3	Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана. Цаашид нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагыг боловсронгуй болгох урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлнэ.	-2025 оны 8 дугаар сарын байдлаар Монгол Улсын гадаад албан нөөц 5,683.43 сая доллар байгаа нь нийт импортын 6-7 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Засгийн газар 2022 онд "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" тогтоол батлан хэрэгжүүлж байна. Мөн УИХ-ын 2025 оны 49 дүгээр тогтоолоор "Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг"-ийг батлан гадаад валютын нөөц, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр гадаад төлбөрийг төлөх, гадаад зээлийн хөрөнгөөр хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан, эдийн засгийн бодит өгөөжтэй, тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх, үнэт цаасны арилжааг тогтмолжуулж дотоод, гадаад үнэт цаасны зах зээлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлахаар зорилт, арга хэмжээг тусгасан. -Засгийн газраас 2020 онд гаргасан "Номад" бондын 174.3 сая ам.доллар буюу 656.6 тэрбум төгрөгийн төлбөр 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр төлөгдөх хуваарьтай байгаа бөгөөд 2026-2028 оны хооронд нийт 1,130.1 сая ам.долларын төлбөр хугацаа тулсан нь төрийн сангийн мөнгөн хөрөнгө, гадаад валютын албан нөөц, төсөв, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах эрсдэлтэй байна. -Монгол банк 2025 онд эхний 7 сарын байдлаар 7 тн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.9 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд жилийн эцэст ч өмнөх оны үзүүлэлтэд хүрэхгүй байх төлөвтэй байна. Цаашид "Алт-3 хөтөлбөр, "Баянхөндий төсөл" зэрэг алтны олборлолтыг дэмжих арга хэмжээнүүдийн нөлөөгөөр алтны экспорт 2026 онд 20 тн-д хүрч нэмэгдэх төсөөлөлтэй байна. Харин 14 мега төслийн нэг Алт цэвэршүүлэх үйлдвэр барихад санхүүжилт олт тавигдаагүй байна.
3.2.4.3	Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг	-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн нэг гол зорилт болох Газрын тос боловсруулах цогцолбор байгуулах ажил 2016 онд эхэлсэн ба 2028 онд төслийг дуусгахаар

	багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана.	төлөвлөж байна. Гадаад зээлээр бүрэн санхүүжих энэ төслийн нийт өртөг 4.178,8 тэрбум төгрөг юм. 2016-2025 онд 620.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 2026 оны төлөвлөгөөнд гадаадын зээлээр 894.2 тэрбумын санхүүжилт татахаар төлөвлөсөн. Ийм байдлаар цаашид явна гэвэл төлөвлөсөн хугацаандаа дуусахгүй байх эрсдэлтэйгээс гадна энэ төслийн хувьд тодорхойгүй маш олон асуудал байгаа юм. Анх үйлдвэр ашиглалтад орсноор жилд 1.5 сая тн түүхий тос боловсруулан дотоодын хэрэгцээний 80.0 хувийг хангаж, 700 гаруй ажлын байр шинээр бий болгох боломж бүрдэнэ гэж тооцож байв. -Манай улс 2024 оны жилийн эцсийн дүнгээр 897.5 мянган тн бензин, 1,641.5 мянган тн дизель түлш, 97.8 мянган тн онгоцны түлшийг 2,027 сая ам.доллараар импортлон, 4,074.1 мянган баррель боловсруулаагүй нефтийг 322.1 мянган ам.доллараар экспортолжээ. Газрын тосны импортод ОХУ 95 хувийг эзэлж байна.
3.2.5.2	Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ. Стратегийн бараа, түүхий эдээр үндэсний үйлдвэрлэлийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын таатай нөхцөлийг бүрдүүлнэ.	-Монгол Улсын хувьд гол нэрийн экспортын бүтээгдэхүүний үнэ, эрэлт болон валютын ханшаар дамжин төсвийн орлого, Засгийн газрын өрийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэдэг. Экспорт 2025 оны эхний 7 сард 7.8 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар буурлаа. Үүнд нүүрсний экспортын биет хэмжээ 44.4 сая тн буюу өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар, нүүрсний хилийн үнэ тн тутамд 70 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 40.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. -Харин 2026 оны төсвийн төслийн танилцуулгад 2025 оны эцэст экспорт 15.8 тэрбум ам.доллар, 2026 онд импорт 13.4 тэрбум ам.доллар, экспорт 16.6 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 3.2 тэрбум ам.долларын ашигтай гарах тухай дурджээ.
3.2.5.3	Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална. Түүхий эд бэлтгэл, бөөний болон жижиглэн худалдаанд үнийн зохиомол хэлбэлзэл, монопол, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулна. Дотоодын үйлдвэрлэл, зах зээлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	Өнөөгийн байдлаар импортын 38.7 хувийг БНХАУ, 23 хувийг ОХУ, 12.3 хувийг Япон, 4.4 хувийг БНСУ, 4 хувийг АНУ, 2.5 хувийг ХБНГУ эзэлж, нийт импортын 85.6 хувийг бүрдүүлж байна. -Засгийн газраас бүх төрлийн боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардлагатай барилгын материал, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх, НӨАТ-ын төлөлтийг хойшлуулах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлж байгаа нь дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэхэд чиглэж байгаа гэж төсвийн төслийн танилцуулгад дурджээ. Гэтэл эдүгээ барилгын материалын 33.8 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 66.2 хувийг импортоор хангаж байгаа нөхцөлд дээрх арга хэмжээ зарим талаар импортыг хөхиүлэн дэмжих механизм гэж харагдаж байна.
3.2.2.6.	Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	-Төрийн албан хаагчдын цалинг 2025 оны эхнээс 6.0 хувиар нэмэгдүүлж, 2026 онд мөн энэ хэмжээнд өсгөхөөр төлөвлөсөн. -Төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээг цахимжуулах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээ хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд төсөвт байгууллагын цалин хөлс, үндсэн үйл ажиллагааны урсгал зардал буурна. -2026 оны улсын төсөвт орон нутагт ажиллах төрийн албан хаагчдын түрээсийн орон сууц барихад зориулж 20 орчим тэрбум төгрөг суулгасан байна.
3.4.2.1.	Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд	-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "...гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангаж, экспортод гаргах чиглэл баримтална" гэж заасан ба

3.4.2.2.	нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ. Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна.	үүнээс хойш үндсэндээ хоёр жил өнгөрөөд байгаа боловч дорвитой үр дүн гараагүй хэвээр байна. -Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний “Дотоодын үйлдвэрлэлээр хангасан хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлсэн байна” гэсэн зорилтын хүрээнд 7 төсөл, арга хэмжээ төлөвлөж, бүгдийг нь улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан боловч нэгээс бусдад нь санхүүжилт тавиагүй байна. -Гадаад худалдааны статистикаас харвал 2025 оны эхний 7 сард хүнсний бүтээгдэхүүний импорт 682 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувь буюу 55 сая ам.доллараар нэмэгдсэн нь анхаарал татах асуудал болж байна. Иймээс “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай. Харин 2026 оны төсвийн төсөлд “Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторийн мэдээллийн удирдлагын программ хангамжийн нэгдсэн систем” бий болгохоор тусгасан чухал ололт гэж үзэж байна.
3.4.1.9.	Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгож иргэдийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний улмаас үүсэх санхүүгийн эрсдэлээс хамгаална.	-ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн нийт орлогыг 2,551.8 тэрбум, зарлагыг 2,273.3 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь үндсэндээ өнгөрсөн оны түвшинд байна. -Эрүүл мэндийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 211.6 тэрбум, гадаадын зээл тусламжаар 1,089.5 тэрбум төгрөг, нийт 1.3 их наяд төгрөгийн санхүүжилт хийж, Хавдрын эмнэлэг, Эд эс, эрхтэн шилжүүлэх суулгах эмнэлэг, Зүрх судасны эмнэлгийн бүтээн байгуулалтыг эхлүүлэн гадаадын зээлээр 17 аймгийн эмнэлгийн барилгыг шинэчлэх, эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийг сайжруулж, нэн шаардлагатай тоног төхөөрөмж авна. -Гэвч иргэд бүс нутагтаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж бүрдээгүй учраас санхүүгийн дарамт хэвээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж нь шалгуур үзүүлэлтүүдтэйгээ уялдахгүй байна. -2026 оны төсвийн төсөлд “хүлээж болохуйц, амьдралын чанар сайжруулах тусламж, үйлчилгээнд иргэний хариуцан төлөх хамтын төлбөрийн хэмжээг нэмэгдүүлж, хэвтэн эмчлүүлэх шаардлагагүй, эмчилгээний үр дүн муутай зарим тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын багцаас хасаж, иргэн өөрөө төлбөрөө төлсний үндсэн дээр авдаг болгон, давхардсан тусламж, үйлчилгээнд дахин санхүүжилт олгохгүй байх зохицуулалт хийх”-ээр заажээ. -Гадаад оронд эмчлүүлэхээр явж байгаа иргэдийн тоо жилд бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2014 онд жилд 58 сая ам.доллар зарцуулж байсан бол энэ дүн 2024 онд 187.4 сая ам.доллар болж өссөн байна.

Дээрх шинжилгээнд үндэслэн үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх хүрээнд дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай гэж үзсэн.

9.1. Үндэсний аюулгүй байдлын асуудлыг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тодорхой тусгах хэрэгтэй. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод томъёолсон “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрд хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болох” зорилт, мөн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгалаа олсон үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах асуудал Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдал тодорхой бус байна.

9.2. Үндэсний аюулгүй байдлын тулгамдсан асуудлуудыг зорилттой нь нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг” гэж, Хүнсний тухай хуульд монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг “стратегийн хүнс” гэж тодорхойлсон бөгөөд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаанд олон улсын стандартад нийцсэн арга зүйг нэвтрүүлэн, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг сайжруулах” тухай зорилтыг бүрэн хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудал юм.

9.3. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх” тухай чухал санаа байгаа ч энэ зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй тул ойрын үед хэрэгжих магадлал бага юм. Тиймээс цаашид хариуцлагатай уул уурхайн зарчмууд буюу олон талын оролцоог хангах, ил тод нээлттэй байх, хуулийн сахин дээдлэх, байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх, ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах, үр өгөөжтэй байх, хүмүүнлэг ёс зүйтэй байх, дэвшилтэт технологид суурилсан байх зэрэг шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх зорилт хүлээгдэж байна.

9.4. Хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах нь тулгамдсан асуудал болж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, бизнес эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлд төрийн зохицуулалтыг хялбарчилж, хувийн секторын чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, төрөөс бизнесийн салбарт хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, зах зээл дэх төрийн зохицуулалтыг багасгаж, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

9.5. Хөгжлийн зорилтуудыг дэмжсэн төсвийн төслийг боловсруулах шаардлагатай. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Нэг хүнд ногдох ДНБ-ийг 8,000-10,000 ам.долларт хүргэж, хүний хөгжлийн үзүүлэлтийг 10 байраар ахиулан, ядуурлын түвшнийг хоёр дахин бууруулна”, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтэд ядуурлын түвшнийг 22 хувьд хүргэж бууруулна гэсэн зорилт дэвшүүлсэн боловч хэдий хэр төсөв мөнгө зарцуулж, ямар төсөл, арга хэмжээгээр хэрэгжүүлэх нь төсвийн төслөөс харагдахгүй байна. ҮСХ, Дэлхийн банкны судалгаанаас харахад ядуурлын түвшин 30 орчим хувьд хадгалагдсаар байгаа нь үүний нотолгоо юм. Мөн Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, тэгш боломж бүхий мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлсэн байна” гэсэн зорилтын хүрээнд хоёр арга хэмжээ төлөвлөсөн боловч төсвийн төсөлд санхүүжилт огт тавигдаагүй байна.

9.6. Эрүүл мэндийн даатгал, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлэх алхам хийж байгаа ч зарлагын болон гарцын өсөлтийн уялдаа хангалтгүй, гүйцэтгэлийг үнэлэх механизм боловсронгуй биш учраас үр дүн тодорхойгүй байна. Гадаад оронд эмчлүүлэхээр явж байгаа иргэдийн тоо, зардал жил бүр нэмэгдэж ирсэн нь иргэдэд учрах санхүүгийн дарамт буурахгүй байгааг харуулж байна. Хязгаарлагдмал нөөцөөр хэрэгцээг хангах нь тулгамдсан асуудал учраас өнөөгийн холимог тогтолцоо хэвээр үргэлжлэх нөхцөлд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт тогтоож, үнэлгээжүүлэх, цаашдаа эрүүл мэндийн даатгалыг хувийн даатгалын байгууллагуудад үе шаттайгаар шилжүүлэх, төр эмнэлгийн үйлчилгээний үнэ хэт өсөхөөс сэргийлэх арга хэмжээ авч байх гарц шийдэл байж болохоор байна.

10. ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ШАЛГУУРЫГ ХАНГАСАН ЭСЭХ

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна. Өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1-т заасан тусгай шаардлагуудыг хангасан байна.

Хүснэгт 3. Төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байдал

Заалт	Тусгай шаардлага	Өргөн мэдүүлсэн төсөл
6.1.1	МУНТ-ийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;	31,600 тэрбум төгрөгийн тэнцвэржүүлсэн орлоготой байна.
6.1.2	МУНТ-ийн суурь тэнцэл нь тухайн жилийн ДНБ-ийн хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх;	Суурь тэнцэл 2,048 тэрбум төгрөг буюу ДНБ-ийн хоёр хувьтай тэнцэх ашигтай байна.
6.1.3	МУНТ-ийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн ДНБ-ийн 30 хувиас хэтрэхгүй байх;	Урсгал зарлага 24,549.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ийн 24 хувьтай тэнцэнэ.
6.1.4	Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн ДНБ-ийн 60 хувиас хэтрэхгүй байх.	Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 51,200 тэрбум төгрөг буюу ДНБ-ийн 50 хувьтай байна.
19.9	2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -1,380 тэрбум төгрөг буюу ДНБ-ийн -1.3 хувьтай байна.

11. УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ЭСЭХ

Төсвийн төсөл нь хөгжлийн төлөвлөлтөд нийцтэй байх талаар Төсвийн тухай хуулийн 27.1.8-д “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх” гэж заасан байдаг. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний зорилт нь “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тодорхойлсон “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” зэрэг үндсэн 4 чиглэлийг үргэлжлүүлэн, “хүн төвтэй” хөгжлийн үзэл санаанд нийцсэн “эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох”-ыг зорьж, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэх явдал хэмээн төсвийн төслийн танилцуулгад дурджээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө нь “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль”-ийн төсөлд тусгагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдтэй зорилгын түвшинд уялдсан, эдгээрт тусгагдсан зорилтыг хангахад чиглэсэн хэдий ч энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан 61 тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлэх 316 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд нийт 85.2 их наяд төгрөг шаардлагатай бөгөөд энэ нь 2026 онд хүрэхээр зорьж буй ДНБ-ий нэрлэсэн дүнгийн 83.3 хувьтай тэнцүү байна.

Төсвийн тухай хуулийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх” гэж заасны дагуу нийт төсөл, арга

хэмжээний 349 шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгж, суурь болон зорилтот түвшин, бодлогын үндэслэлийг тогтоон, шаардагдах санхүүжилтийн хэмжээг тооцож гаргажээ

Хүснэгт 4. Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан бодлого, зорилго, арга хэмжээ, нийт санхүүжилтийн хэмжээ

Бодлогын хүрээ	Зорилт (үр дүн), арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн тоо				Нийт шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, тэрбум төгрөг	Эзлэх хувь
	ТЕЗ	Хөтөлбөр	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт		
Бүсчилсэн хөгжлийн бодлого	11	17	88	96	29,045.4	34.1
Хүний хөгжлийн бодлого	15	19	51	60	4,309.3	5.1
Эдийн засгийн бодлого	19	25	112	120	50,680.3	59.4
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	16	24	65	73	1,195.1	1.4
Дүн	61	85	316	349	85,230.1	100

Эх сурвалж: Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө

Санхүүжилтийн эх үүсвэрээр нь ангилж үзэхэд улсын төсвийн хөрөнгөөр 225, гадаадын зээлээр 23, орон нутгийн төсвөөр 12, дотоодын хөрөнгө оруулалтаар 8, гадаадын тусламжаар 7, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 10, бусад эх үүсвэрээр 31 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Санхүүжилтэд эзлэх хувиар авч үзвэл, 21.8 хувийг улсын төсөв, 11.8 хувийг гадаадын зээл, 7.5 хувийг орон нутгийн төсөв, 9.9 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 0.6 хувийг гадаадын тусламж, 23.5 хувийг төр хувийн хэвшлийн түншлэл, 8.5 хувийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, 4.6 хувийг гадаадын хөрөнгө оруулалт болон 11.9 хувийг бусад эх үүсвэр эзэлж байна.

Хүснэгт 5. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон байдал

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Хэрэг-жүүлэх төсөл, арга хэмжээ	Санхүү-жилтийн нийт дүн, тэрбум төгрөг	Нийт санхүү-жилтэд эзлэх хувь	Тухайн жилд шаардагдах санхүүжилт, тэрбум төгрөг	Тухайн жилийн санхүү-жилтэд эзлэх хувь	Санхүү-жилтийн дүн нь тодорхойгүй төсөл
1	Улсын төсөв	225	12,365.2	14.5	4,235.5	21.8	5
2	Гадаадын зээл	23	11,962.7	14.0	2,293.3	11.8	
3	Орон нутгийн төсөв	12	5,360.2	6.3	1,449.8	7.5	
4	Дотоодын хөрөнгө оруулалт	8	5,240.0	6.1	1,925.6	9.9	
5	Гадаадын тусламж	7	353.8	0.4	107.5	0.6	
6	Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)	10	25,781.5	30.2	4,559.4	23.5	1
7	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	3	6,356.2	7.5	1,651.5	8.5	
8	Гадаадын хөрөнгө оруулалт	3	4,002.5	4.7	901.6	4.6	

9	Улсын төсөв, гадаадын зээл	4	1,145.4	1.3	368.0	1.9	
11	Бусад эх үүсвэр	1	-	0.0	-	0.0	1
12	Гадаадын зээл, ТХХТ	1	1,052.0	1.2	210.4	1.1	
13	Улсын болон орон нутгийн төсөв	1	15.0	0.0	15.0	0.1	
14	Улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	1	16.5	0.0	4.1	0.0	
15	Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл	1	72.0	0.1	51.0	0.3	
16	Улсын төсөв, гадаадын тусламж	1	14.2	0.0	9.0	0.0	
17	Гадаадын зээл, орон нутгийн төсөв	1	8,460.2	9.9	909.6	4.7	
18	ТХХТ, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	1	1.1	0.0	1.1	0.0	
19	ТХХТ, дотоодын хөрөнгө оруулалт	1	473.0	0.6	142.0	0.7	
20	Улсын төсөв болон бусад эх үүсвэр	2	76.8	0.1	76.8	0.4	
21	Улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын тусламж	2	1,873.8	2.2	301.5	1.6	
22	Улсын төсөв, үнэт цаас, орон нутгийн төсөв	1	200.0	0.2	80.0	0.4	
23	Үнэт цаас, орон нутгийн төсөв	2	400.0	0.5	150.0	0.8	
24	Гадаадын зээл, тусламж	1	-	0.0	-	0.0	1
25	Үнэт цаас	1	-	0.0	-	0.0	1
26	Хөрөнгийн эх үүсвэр нь тодорхойгүй төслүүд	3	7.6	0.0	-	0.0	2
Нийт		316	85,230.1	100.0	19,443.0	100.0	11

Эх сурвалж: ТТБЗ-ийн тооцоолол

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.37-д заасны дагуу Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ тухайн оны улсын төсвийн төсөлд хэрхэн туссаныг харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 6. Монгол Улсын хөгжлийн бодлого болон төсөв хоорондын уялдаа

Тэргүүлэх чиглэл	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Төсөл арга хэмжээ	2026 оны төсөвт санхүүжилт тавигдсан эсэх	
			Тийм	Үгүй
Нэг. Бүсчилсэн хөгжлийн бодлого	1.1. Бүсүүдийн тэнцвэртэй хөгжлийг хангасан байна.	13	7	6
	1.2. Стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээний үйл ажиллагааны үр дүн нэмэгдсэн байна.	1	1	0
	1.3. Чөлөөт бүс дэх худалдаа, бараа бүтээгдэхүүний эргэлтийг сайжруулсан байна.	2	0	2

	1.4. “20” минутын хотыг хөгжүүлсэн байна.	2	0	2
	1.5. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, тэгш боломж бүхий мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлсэн байна.	2	0	2
	1.6. Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.	13	4	9
	1.7. Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоог нэмэгдүүлсэн байна.	15	6	9
	1.8. Дулаан хангамжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	9	1	8
	1.9. Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.	23	12	11
	1.10. Иргэдэд бүс нутагтаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.	3	1	2
	1.11. Нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулсан байна.	5	1	4
Хоёр. Хүний хөгжлийн бодлого	2.1. Халдварт болон халдварт бус өвчний шалтгаант нас баралтыг бууруулсан байна.	12	5	7
	2.2. Сургуулийн өмнөх боловсролын чанартай үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийн суурийг бий болгосон байна.	3	1	2
	2.3. Олон улсад өрсөлдөхүйц чанартай, тэгш хүртээмжтэй ерөнхий боловсролыг хөгжүүлсэн байна.	8	4	4
	2.4. Боловсролын чанарыг сайжруулсан байна.	3	0	3
	2.5. Өрсөлдөх чадвартай, тэгш боломж бүхий дээд боловсролыг хөгжүүлсэн байна.	3	0	3
	2.6. Хүн бүрд боловсрол эзэмших, тасралтгүй суралцах тэгш боломжийг бүрдүүлсэн байна.	2	0	2
	2.7. Боловсролын удирдлага, менежментийнүр ашиг, оновчтой байдал сайжирсан байна.	2	0	2
	2.8. Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлсэн байна.	2	1	1
	2.9. Гэр бүлийн гишүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг сайжруулсан байна.	4	0	4
	2.10. Хүүхэд хамгааллыг сайжруулсан байна.	3	1	2
	2.11. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох оролцоог нэмэгдүүлсэн байна.	1	1	0
	2.12. Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлсэн байна.	1	0	1
	2.13. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн байна.	2	0	2
	2.14. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлсэн байна.	1	0	1
	2.15. Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	4	1	3
Гурав. Эдийн засгийн бодлого	2.1. Дотоодын үйлдвэрлэлээр хангасан хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлсэн байна.	7	1	6
	3.2. Мал аж ахуйг тогтвортой, бүсчилсэн байдлаар хөгжүүлсэн байна.	3	1	2
	3.3. Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлсэн байна.	4	1	3

	3.4. Малын халдварт өвчний гаралтын тайван байдлыг хадгалсан байна.	6	1	5
	3.5. Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн өссөн байна.	15	1	14
	3.6. Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангасан байна.	9	0	9
	3.7. Аж ахуй эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, зах зээлд үйл ажиллагаа явуулах таатай орчин бүрдсэн байна.	1	0	1
	3.8. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлсэн байна.	1	0	1
	3.9. Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлсэн байна.	2	0	2
	3.10. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан байна.	5	1	4
	3.11. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлсэн байна.	6	1	5
	3.12. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, байгалийн унаган төрхийг хадгалсан байна.	2	0	2
	3.13. Усны нөөц, хангамжийг нэмэгдүүлсэн байна.	4	0	4
	3.14. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлсэн байна.	11	1	10
	3.15. Экспортыг нэмэгдүүлсэн байна.	4	0	4
	3.16. Бүх төрлийн тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.	20	7	13
	3.17. Гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавх нэмэгдсэн байна.	3	2	1
	3.18. Боомтын зорчигч, ачаа тээврийн нэвтрэлтийг нэмэгдүүлсэн байна.	8	0	8
	3.19. Бичил, жижиг, дунд бизнесийн эдийн засагт оруулах хувь нэмэр нэмэгдсэн байна.	1	0	1
Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	4.1. Шударга байдлын үзүүлэлт сайжирсан байна.	1	0	1
	4.2. Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөр-жүүлж, сөрөн тэсвэрлэх чадавх бүрдсэн байна.	15	3	12
	4.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үр дүн сайжирсан байна.	1	0	1
	4.4. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлсэн байна.	3	1	2
	4.5. Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлсэн байна.	3	0	3
	4.6. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал сайжирч, зах зээлийн зарчимд шилжсэн байна.	1	0	1
	4.7. Нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг дээшлүүлсэн байна.	20	5	15
	4.8. Архивын баримтыг ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд архивын лавлагаа үйлчилгээний хугацааг багасгасан байна.	3	0	3
	4.9. Шүүхийн индексийг сайжруулсан байна.	5	2	3
	4.10. Төрийн аудитын байгууллагын чадамжийг нэмэгдүүлсэн байна.	1	0	1

4.11. Монгол Улсын гадаад бодлогын байр суурийг бататгаж, олон улс дахь нэр хүнд, нөлөөг бэхжүүлсэн байна.	2	0	2
4.12. Цахим засаглалын хөгжлийн индексийн үзүүлэлт сайжирсан байна.	5	1	4
4.13. Кибер аюулгүй байдлын орчин сайжирсан байна.	1	0	1
4.14. Дэлхийн гарааны бизнесийн экосистемийн индексийн үзүүлэлт сайжирсан байна.	2	0	2
4.15. Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн үзүүлэлт сайжирсан байна.	1	0	1
4.16. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн бэлэн байдлыг нэмэгдүүлсэн байна.	1	0	1
Нийт	316	76	240

Эх сурвалж: Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл
Эндээс харахад Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнийн хүрээнд нийт 316 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 126 төсөл нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих ба үүнээс 60 хувь буюу 76 төсөл, арга хэмжээг 2026 оны төсвийн төсөлд тусгасан байна.

Хүснэгт 7. Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний зорилтууд болон улсын төсвийн санхүүжилтийн хоорондын уялдаа

Бодлогын хүрээ	Тухайн жилд шаардагдах санхүүжилт, сая төг	Үүнээс улсын төсвөөс санхүүжүүлэх дүн, сая төг	Тухайн жилд шаардагдах санхүүжилтэд эзлэх хувь	2026 оны төсөвт туссан дүн, сая төг	Төсвөөс санхүүжүүлэх дүнд эзлэх хувь
Бүсчилсэн хөгжлийн бодлого	6,157,227.2	1,122,394.9	18.2	591,698.4	52.7
Хүний хөгжлийн бодлого	1,885,423.8	1,178,831.9	62.5	131,101.1	11.1
Эдийн засгийн бодлого	10,977,334.6	1,568,800.7	14.3	494,314.8	31.5
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	423,055.7	365,510.3	86.4	88,186.1	24.1
Дүн	19,443,041.3	4,235,537.8	21.7	1,305,300.4	30.8

Эх сурвалж: ЭЗХЯ

2026 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тухайн жилд шаардагдах 19.4 их наяд төгрөгийн 6.7 хувь буюу 1.3 их наяд төгрөгийг улсын төсвөөс гаргахаар тооцсон байх бөгөөд барилга байгууламж шинэчлэх, засварлах болон тоног төхөөрөмж худалдан авах зардлыг нэмбэл 16.4 хувь буюу 3.2 их наяд төгрөг болж байна. Үлдэх 80 гаруй хувийг үнэт цаас, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлээр санхүүжүүлнэ гэж ойлгогдож байгаа ч эх үүсвэр нь шийдэгдээгүй олон төсөл, арга хэмжээ байгаагаас үзвэл 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт тун хангалтгүй байхаар харагдаж байна. Ялангуяа төр, хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжих ямар ч баталгаа байхгүй юм.

2026 оны төсвийн төсөл нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тодорхой хэмжээнд нийцтэй байна. Гэхдээ төсвийн төсөл, хөгжлийн төлөвлөгөөний нийцтэй байдлыг бүрэн хангах асуудлыг цаашид анхаарах шаардлагатай бөгөөд энэ хүрээнд дараах асуудлуудыг байна гэж дүгнэлээ.

11.1. Хөгжлийн төлөвлөлтийг бодитой төлөвлөхгүй байгаа төсвийн төсөл, хөгжлийн төлөвлөлтийн нийцэлд сөргөөр нөлөөлж байна. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө нь урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдтэй зорилгын түвшинд уялдсан, эдгээрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн боловч төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг бүрэн санхүүжүүлэх нийт дүн улс орны өнөөгийн бодит боломжоос хэт давсан байгаа нь төлөвлөгөө хугацаандаа хэрэгжих боломжийг бууруулж байна. Мөн хөгжлийн төлөвлөгөө нь Төсвийн тухай хуулийн шаардлагыг ерөнхий түвшинд хангасан ч хөрөнгө оруулалтын үндэслэл, нэгж төслийн үр ашгийн тооцоо, үр дүн, зардал-үр дүнгийн хамаарал сул буюу төсвийг тооцож төлөвлөгөөнд тусгахдаа шалгуур үзүүлэлт нь үр дүнтэй шууд холбоотой байх зарчмыг баримтлаагүй, зарим төсөл, хөтөлбөрийн зардал, санхүүжилт, зорилтот үр дүн нь тодорхойгүй байна.

11.2. Хөгжлийн төлөвлөлтийн төлөвлөлт, хяналт, тайлагналыг сайжруулах шаардлагатай байна. Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төсөл, байршил, газрын зөвшөөрөл, төсөвт өртөг нь тодорхойгүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх нь зүйтэй. “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуульд хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг нэн тодорхой, харилцан уялдаатай боловсруулж баталсан байх, тэдгээр бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтууд, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, төсвийн эх үүсвэрийн тооцооллыг урьдчилан хийсэн байх тухай заасан. Ингэснээр чухам ямар төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хэдэн онд, ямар хэмжээний хөрөнгө шаардлагатай, энэ эх үүсвэрийг нийт эдийн засагт дарамт учруулахгүй, гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэхгүйгээр бүрдүүлэх боломжтойг тодорхойлсноор макро эдийн засгийн зохистой байдал, тэнцлийг хангахуйц хөгжлийн бодлого боловсруулах нөхцөл бүрдэх юм. Гэвч төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, мониторинг, тайлагналын аль ч шатанд гарч буй доголдол арилахгүй байна. Энэ нь аливаа төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй он дамжиж сунжрах нэг шалтгаан болж байна. Төслүүдийн санхүүжилтийг тодорхой зааж өгөхийн гол зорилго нь ДХТХМ-ийн төсөөлөл дэх төсвийн зарлагыг бодитой болгох явдал юм. Ийм учраас авто болон төмөр зам, эрчим хүч, аж үйлдвэрийн парк зэрэг зардал ихтэй стратегийн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг нарийвчлан тооцож төлөвлөх хэрэгтэй.

11.3. Төсвийн сахилга бат, хөрөнгө оруулалтын үр ашигт анхаарал хандуулах шаардлага байна. Томоохон төсөл, хөтөлбөрүүдийн ТЭЗҮ, зураг төсөв, өртөг зардал, хариуцах эзэн, байгууллага тодорхой бус, хөрөнгө оруулалтын ач холбогдол, үр өгөөжийн тооцоолол хангалтгүй байгаа нь төсвийн хуваарилалт оновчгүй байх, хэрэгжилт зогсонги байдалд орох эрсдэлийг дагуулж, хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ